

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

МУ	Монгол улс
ЗГ	Засгийн газар
ТАГ	Төрийн аудитын газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ӨМАГ	Өмнөговь аймгийн Аудитын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ХАК	Хувийн аудитын компани
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТАУС	Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын систем
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2017 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2017.07.01

Даланзадгад сум

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар нь 2017 онд дэвшүүлсэн зорилт, аудитын төлөвлөгөө болон үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг бүрэн хэрэгжүүлсэн бөгөөд 2017 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны үр дүнг тайлагнаж байна.

Нэгдүгээр бүлэг: Удирдлага зохион байгуулалтын талаар

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар нь 2017 онд “ур чадвар, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх зорилт дэвшүүлэн” Монгол Улсын Төрийн аудитын тухай хууль болон бусад хууль тогтоомжийг удирдлага болгон аудитын олон улсын стандартын хүрээнд Үндэсний аудитын газарт нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний аудитын болон үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг мөрдөж ажиллалаа.

Тайлант хугацаанд 10 орон тоотойгоор 2045 хүн/өдөр зарцуулан ажиллаж, 1 гүйцэтгэлийн аудит, 1 нийцлийн аудит, 209 байгууллагад санхүүгийн аудитыг хийж, 20,531.3 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 14,522.1 сая төгрөгийн алдаа зөрчлийг аудитын явцад залруулж, 13.1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 5,996.4 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлэн, 22 байгууллагад хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах 25, бүртгэл тайлагнал, дотоод хяналтыг сайжруулах 6 нийт 31 заалт бүхий зөвлөмжийг өгч, 290.2 сая төгрөгийг улс, орон нутгийн төсөвт төвлөрүүллээ.

Төлбөрийн актны биелэлт 100 хувь, албан шаардлагын хэрэгжилт 24,4 хувийн биелэлттэй ажиллаж, 2017 оны эхний хагас жилд төсвөөс авсан нэг төгрөгийн санхүүжилтээр 2.3 төгрөгийн үр өгөөжийг бий болгож ажиллалаа.

2017 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны үр дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулсан зарим үзүүлэлтүүд:

Хүснэгт №1

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016 он	2017 он
1	Санхүүгийн тайлангийн аудит	тоо	151	145
2	Гүйцэтгэлийн аудит	тоо	4	1

3	Нийцлийн аудит	тоо	4	1
4	Аудитын дүн	тоо	159	147
5	1 төгрөгт ногдох үр өгөөж	мөнгөн дүн	2.9	2.3
6	Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн орлого	мөнгөн дүн	37.1	290.2
7	Тогтоосон төлбөрийн акт	тоо	7	6
		мөнгөн дүн	30.3	13.1
		Үүнээс: хэрэгжсэн	10.2	4.7
8	Өгсөн албан шаардлага	тоо	17	39
		мөнгөн дүн	10,516.3	5,996.4
		Үүнээс: хэрэгжсэн	593.7	1,463.0
9	Өгсөн зөвлөмж	тоо	144	31
		хэрэгжүүлсэн	21	2
10	Илрүүлсэн алдаа, зөрчил	Илрүүлсэн	171,1159.9	20,531.3
		Залруулсан	87,877.0	14,522.1
11	Албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал	тоо	16	6
		хэрэгжсэн	15	6
12	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	тоо	0	0

Хоёрдугаар бүлэг: Санхүүгийн тайлангийн аудитын талаар

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 203 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”-ын дагуу санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын систем (СТАУС) 2 программыг 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийхэд бүрэн ашиглалаа. Санхүүгийн аудитаар уг программыг ашигласнаар тодорхой хэмжээгээр цаг хугацаа хэмнэж, хянан удирдах үйл ажиллагааны арга зүйг стандартын дагуу хийж хэрэгжүүлэн 1460 хүн/өдөр зарцуулан ажиллалаа.

Улс, орон нутгийн төсвийн байгууллага, төсөл сан, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн нийт 145 санхүүгийн тайланд аудит хийх хуваарийг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/72 дугаар тушаалаар батлуулж, 75,5 хувийг төрийн аудитын газар, үлдэх 24,0 хувийг хувийн аудитын компаниар гэрээгээр хийж гүйцэтгүүллээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар итгэл үзүүлэхэд баримтлах журмын дагуу 31 байгууллагад итгэл үзүүлж, 32 байгууллагыг түүвэрт хамруулсан байгаа нь нийт хамрагдвал зохих байгууллагын 30,1 хувийг эзэлж байна.

2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар 145 байгууллагад өгсөн санал дүгнэлтийн 140 буюу 96,6 хувийг зөрчилгүй, 5 буюу 3,4 хувийг хязгаарлалттай санал дүгнэлт эзэлж байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 14,935.3 сая төгрөгийн зөрчил илрүүлж, илрүүлсэн зөрчлийн 97,2 хувь буюу 14,522.1 сая төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулан тусгуулж ажиллалаа.

Нийт аудитын илрүүлэлтийн 3,5 хувийг төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй, 82,7 хувийг нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй, 0,2 хувийг арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй, 1,5 хувийг хууль тогтоомжийн хэрэгжилттэй, 0,5 хувийг дотоод хяналттай, 0,3 хувийг худалдан авалттай холбоотой, 11,3 хувийг бусад төрлийн алдаа зөрчил эзэлж байна.

Тайлант хугацаанд тогтоосон 4.7 сая төгрөгийн төлбөрийн актын 100 хувийг, 408.5 сая төгрөгийн албан шаардлагын 78,8 хувийг хэрэгжүүлж, улс, орон нутгийн төсөвт 26.1 сая төгрөгийг төвлөрүүлэн, 6 албан тушаалтанд хариуцлага тооцуулах саналыг хүргүүллээ. Тэргүүлэх аудиторын тушаалаар төлбөрийн акт, албан шаардлагыг баталгаажуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хүснэгт 2

Төсвийн захирагч	Алдаа, зөрчил			
	Нийт	Залруулсан	Төлбөрийн акт	Албан шаардлага
Төсөвт байгууллага	14,565.6	14,357.2	4.7	203.7
ОНӨААТҮГ	369.7	164.9	0	204.8
НИЙТ ДҮН	14,935.3	14,522.1	4.7	408.5

Харин өмнөх оноос шилжиж ирсэн 5.4 сая төгрөгийн төлбөрийн актын 22,2 хувийг барагдуулж, 197.7 сая төгрөгийн албан шаардлагын үлдэгдэлтэй байна.

Тайлант онд өгсөн зөвлөмжийн 6,5 хувийг хэрэгжүүлж, 29 зөвлөмжийн үлдэгдэлтэй байна. 2017 оны эхний хагас жилд 26.1 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөжийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлэн ажиллалаа.

Гуравдугаар бүлэг: Гүйцэтгэлийн аудитын талаар

УАГ-ын нэгдсэн удирдамж, төлөвлөгөөний дагуу 1 гүйцэтгэлийн аудит хийж, 280 хүн/өдөр зарцуулан ажиллалаа.

2017 оны эхний хагас жилд хийсэн гүйцэтгэлийн аудитаар 3,066.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлсэн нь хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой алдаа зөрчил байна. Үүнд нийт 3,067.1 сая төгрөгийн албан шаардлага өгч хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

Өмнөх оны үлдэгдэл 211.1 сая төгрөгийн төлбөрийн актны 2,4 хувийг барагдуулж, 48.8 сая төгрөгийн албан шаардлагын үлдэгдэлтэй, 5.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүллээ.

3.1 2016 оны Улс төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн, үр өгөөж /УАГ-ГАГ/2017/02-ӨМАГ/:

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 68 төсөл арга хэмжээнд 22,759.9 сая төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөснөөс 90 төсөл арга хэмжээнд 21,467.7 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон байна.

Хийгдсэн хөрөнгө оруулалтыг өмнөх онтой харьцуулахад боловсрол, соёлын салбар 1,841.2 сая төгрөг, төрийн захиргааны салбар 3,330.0 сая төгрөг, зам тээвэр барилга хот байгуулалтын салбар 7,467.2 сая төгрөг, хүнс хөдөө аж ахуйн салбар 98.8 сая төгрөгөөр буурсан бол эрүүл мэнд, спортын салбар 493.2 сая төгрөг, байгаль орчин аялал жуулчлалын салбар 4,164.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант онд гэрээ байгуулан гүйцэтгэж байгаа ажлын 64.8 хувь нь хугацаандаа, 35.2 хувь нь 1-166 хоногоор хугацаа хэтрүүлэн ашиглалтад орсон байна.

Зарим хөрөнгө оруулалт ашиглалтын явцад чанарын шаардлага хангахгүй, гүйцэтгэгч компани улсын комиссоос өгсөн үүрэг даалгаварыг хэрэгжүүлээгүй, эзэмшигч байгууллага хөрөнгийг бүртгэлд тусгаагүй, ашиглалт хамгаалалт байхгүй зэрэг нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байна.

Аудитаар нийт 3,066.8 сая төгрөгийн зөрчил илрүүлж сүүлийн хагас жилд хэрэгжилт тооцох 3 албан шаардлагыг хүргүүлж ажиллалаа.

Дөрөвдүгээр бүлэг: Нийцлийн аудитын талаар

УАГ-ын нэгдсэн удирдамж, төлөвлөгөөний дагуу 1 нийцлийн аудит хийж, 305 хүн/өдөр зарцуулан ажиллалаа.

2017 оны эхний хагас жилд хийсэн нийцлийн аудитаар 2,529.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлсний 91.5 сая төгрөг буюу 3,6 хувийг НББ, тайлагналтай, 2,192.9 сая төгрөг буюу 86,7 хувийг хууль, тогтоомжийн хэрэгжилттэй, 244.8 сая төгрөг буюу 9,7 хувийг худалдан авалттай холбоотой алдаа зөрчил гарсан бөгөөд нийт 2,520.8 сая төгрөгийн албан шаардлага өгсөний 45,3 хувийг хэрэгжүүлэн ажиллалаа.

Өмнөх оны үлдэгдэл 9.0 сая төгрөгийн төлбөрийн актаас 100 хувь, 7,101.2 сая төгрөгийн албан шаардлагын 87,9 хувийг хэрэгжүүлж, 259.1 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүллээ.

4.1 Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт /УАГ-НАГ/2017/01-НА-ӨМАГ/:

ОНХНС-аас 21,515.0 сая төгрөгийн санхүүжилт олгогдсоноос Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2.1¹, Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоол “Орон нутгийн төсвийн аргачлал батлах тухай” аргачлалыг баримтлан ОНХС-н орлогын шилжүүлгийг сумдад 8,938.4 сая төгрөг буюу 41,5 хувь, аймгийн ОНХС-д 12,576.5 сая төгрөг буюу 58,4 хувийг хуваарилахаар тооцож, батлагдсан хувиарийн дагуу олгожээ.

Аудитаар орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, худалдан авах ажиллагааны журам зөрчсөн, ТЭЗҮ, зураг төсөв нь батлагдаагүй, санхүүжилтээ аваад ажлаа хийгээгүй, хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй зэрэг зөрчлүүд илэрсэн.

Өмнөх онд хийсэн нийцлийн аудитаар 9,558.6 сая төгрөгийн зөрчил илэрснээс 374.6 сая төгрөгийн 9 зөвлөмж, 9,169.2 сая төгрөгийн 7 албан шаардлага, 14.8 сая төгрөгийн 2 төлбөрийн актыг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн бөгөөд хэрэгжилт 100 хувьтай хангагдсан.

Орон нутгийн хөгжлийн сангийн 2016 оны зарцуулалтад хийсэн нийцлийн аудитаар 2,529.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь өмнөх онтой харьцуулахад

¹ Энэ хуулийн 59.2.1-д зааснаас бусад хэсгийн 30-аас доошгүй хувийг хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан хуваарилах

73,6 хувиар буурсан байна. Энэ нь жил бүр хийгдэж байгаа манай аудитын үр дүнг харуулж байна.

Аудитаар нийт 3 төлбөрийн акт, 14 албан шаардлага хүргүүлж хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

Тавдугаар бүлэг: Аймгийн ИТХ-ын захиалгаар хийсэн аудитын талаар

2017 оны аудитын төлөвлөгөөнд тусгагдсны дагуу аймгийн ИТХ-ын захиалгат 2 гүйцэтгэлийн аудитын төлөвлөгөөг батлан эхлүүлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд явагдаж байна.

Зургаадугаар бүлэг: Дотоод ажлын талаар

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/69 дугаар тушаалаар баталсан орон тооны дээд хязгаар болох 11 орон тоотойгоос 10 ажиллагсадтай ажиллалаа. Үүнээс тэргүүлэх аудитор 1, аудитын менежер 1, ахлах аудитор 2, аудитор 2, шинжээч 3, жолооч 1 байна. Мөн нягтлан бодогч мэргэжилтэй 9 ажилтан байгаагаас мэргэшсэн нягтлан бодогч 5, татварын мэргэшсэн зөвлөх 2, биенесийн удирдлагын магистр 3, хууль эрх зүйн магистр 1 байна.

Ажилтан албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийг Авилгын эсрэг хуулийн дагуу хугацаанд нь эрх бүхий албан тушаалтан хүлээн авч, тайлан мэдээг ҮАГ хүргүүлсэн. Мөн авилгаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны 2017 оны төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Албан хаагчдын хувийн хэргийн бүрдэлтэд баяжуулалт хийж, хүний нөөц, үйл ажиллагаатай холбоотой судалгаануудыг ҮАГ-т тухай бүр хугацаанд нь хүргүүлэн ажиллалаа.

2017 оны удирдах ажилтны зөвлөгөөнд тэргүүлэх аудитор, аудитын менежер нар 3 өдрийн ойролцоогоор 22 кредит цагийн сургалтанд хамрагдлаа.

Санхүүгийн аудитын багийн 4 ажилтан, аудитын менежер, тэргүүлэх аудитор нар 210 байгууллагын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн баталгаажуулах аудитыг санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын систем СТАУС-2 программыг ашиглаж хийж гүйцэтгэлээ.

Төрийн аудитын газрын хийж гүйцэтгэсэн аудит, үйл ажиллагааны талаар гарсан мэдээ, аудитын тайланг тухай бүр audit.mn вэб хуудсанд байршуулан ажиллалаа.

Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд төрийн албан хэрэг хөтлөлтийн дагуу хариутай, хариугүй ирсэн бичиг, тушаалуудыг холбогдох хууль, журмын дагуу албан хэрэг хөтлөлтийг эрхлэн явуулж, нууцын журмаар хадгалан хамгаалж ажиллаж байна.

Долоодугаар бүлэг: Санхүүгийн тайлагнал, төсвийн гүйцэтгэл

МУ-ын Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу мод тарих өдрөөр нийтийн эзэмшлийн талбайд мод тарьж, зүлэгжүүлэн тохижууллаа.

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар нь 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд “Улаанбаатар аудит корпораци” ХХК-иар санхүүгийн аудит хийлгэж “Зөрчилгүй” санал дүгнэлт авч ажиллалаа.

2017 онд 197.8 сая төгрөгийн төсөв батлагдаж, эхний хагас жилд 100.6 сая төгрөгийн санхүүжилтийг авч, гүйцэтгэлээр цалин нийгмийн даатгалын шимтгэлд 88.1 сая, хангамжийн бараа материалын зардалд 3.9 сая, томилолтын зардалд 3.2 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 3.6 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 1.1 сая төгрөг, нийт 99.9 сая төгрөгийг зарцуулан 0.7 сая төгрөгийн харилцахын үлдэгдэлтэй байна.

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлан, мэдээг Шилэн дансны тухай хуулийн дагуу хугацаанд нь цахим хуудсанд байршуулан, мэдээг УАГ-т хүргүүлэн, эхний хагас жилийн байдлаар дансны авлага, өглөггүй ажиллалаа.

МУ-ын ЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай” журмын дагуу шилэн дансны хуулийг хэрэгжүүлэн тухай бүр, сар бүр, улирлаар, хагас, бүтэн жилээр оруулах мэдээллүүдийг хуулийн хугацаанд цахим хуудсанд бүрэн оруулж, байгууллага дээрээ шилэн дансны мэдээллийн самбарт байршуулан ажиллаж байна.

Төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангаж ажиллалаа.

Хөрөнгийн тооллого хийх ажлын хэсгийн комиссыг Тэргүүлэх аудиторовын 2017 оны А/7 дугаар тушаалаар томилж, 2017 оны 06 дугаар сарын 05-наас 12-ны хооронд хөрөнгийн тооллогыг явуулж, хөрөнгийг нүд үзэн тоолж аудитын газрын ажилчин,

албан хаагчдын хэрэглэж байгаа эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлийн картыг хүн тус бүр дээр шинэчлэн, тооллогын дүн, тайланг УАГ-т хугацаанд нь хүргүүлсэн.

Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль Төрийн албаны тухай хууль, Төрийн аудитын тухай хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль, эрх зүйн актууд, Төрийн аудитын газрын хөдөлмөрийн дотоод журмыг үндэслэн 2018 оны төсвийн хүрээний мэдэгдлийг өмнөх онуудын төсвийн гүйцэтгэл, холбогдох тооцоо судалгаанд тулгуурлан боловсруулж, УАГ-т хугацаанд нь хүргүүлэн ажиллалаа.

Наймдугаар бүлэг: Дүгнэлт, Санал

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны аудитын болон үйл ажиллагааны төлөвлөгөөний эхний хагас жилд хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг бүрэн хэрэгжүүлэн ажиллалаа.

2017 оны эхний хагас жилийн байдлаар батлагдсан төлөвлөгөөний дагуу 100.6 сая төгрөгийн санхүүжилтийг авч, үйл ажиллагаагаа хэвийн явууллаа.

Тайлант хугацаанд 10 орон тоотойгоор 2045 хүн/өдөр зарцуулан ажиллаж, 1 гүйцэтгэлийн аудит, 1 нийцлийн аудит, 209 байгууллагад санхүүгийн аудитыг хийж, 20,531.3 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 14,522.1 сая төгрөгийн алдаа зөрчлийг аудитын явцад залруулж, 13.1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 5,996.4 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлэн, 22 байгууллагад хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах 25, бүртгэл тайлагнал, дотоод хяналтыг сайжруулах 6 нийт 31 заалт бүхий зөвлөмжийг өгч, 290.2 сая төгрөгийг улс, орон нутгийн төсөвт төвлөрүүллээ.

Төлбөрийн актны биелэлт 100 хувь, албан шаардлагын хэрэгжилт 24,4 хувийн биелэлттэй ажиллалаа.

2017 оны эхний хагас жилд төсвөөс авсан нэг төгрөгийн санхүүжилтээр 2.3 төгрөгийн үр өгөөжийг бий болгож ажиллалаа.

Улс, орон нутгийн төсвийн байгууллага, төсөл сан, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн нийт 145 санхүүгийн тайланд аудит хийсний 24,0 хувийг хувийн аудитын компаниар гэрээгээр хийж гүйцэтгүүллээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар төрийн аудитын газар болон гэрээгээр гүйцэтгүүлсэн байдлыг харьцуулж үзвэл:

Хүснэгт №

Он	Хамрагдвал зохих байгууллагын тоо	Үүнээс				ТАБ-ын эзлэх хувь	ХАК-ийн эзлэх хувь
		ТАГ	ХАК	Итгэл	Түүвэр		
2017	254	95	68	24	67	73.2	26.8
2016	208	95	50	31	32	76.2	23.8

Дээрх хүснэгтээс үзэхэд жил ирэх тусам санхүүгийн тайлангийн баталгаажуулах аудитын тоо нэмэгдэж, санхүүгийн аудитын багийн нэг хүнд ногдох ажлын ачаалал ихсэж байгааг харуулж байна.

СТАУС-2 программ нь үйлчлүүлэгч байгууллагын Е балансад шивэгдсэн санхүүгийн тайланг шууд татдаггүй, стстистик мэдээг нэгтгэж гаргадаггүй, төсвийн ерөнхийлөн захирагч, төвлөрүүлэн захирагч, төсөл сан, ОНӨААТҮГазруудад хэрэгжүүлэх үе шатны ажлууд нь төсвийн шууд захирагчийн байгууллагуудтай адилхан байдаг учраас энэхүү программыг цаашид сайшруулах шаардлагатай байна.

ТАЙЛАН БИЧСЭН:
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Н.ОТГОНБАЯР